



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/362

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 05/06 дугаар зөвлөмжийн 1.6 дахь хэсэг, Хууль зүй дотоод хэргийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан МН/154, МН/357 дугаартай тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт зэрлэг байдлаар ургаж буй ургамлын тархцыг зогсоох, устгах зорилгоор ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Батсүрэн	Аймгийн цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн хошууч
Нарийн бичгийн дарга:	Я.Үер	Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, цагдаагийн ахмад
Гишүүдэд:	Б.Мөнх-Оргил	Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэд ахлагч
	Д.Нэмэхбаяр	Онцгой байдлын газрын ахлах ахлагч
	Б.Түвшинбаяр	Онцгой байдлын газрын салаан захирагчийн туслах, Ахлах ахлагч
	А.Сарандаваа	Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх байрны эмч, цагдаагийн дэслэгч
	Д.Нямцэнд	Хилийн 0287 дугаар ангийн зөрчил шалган шийдвэрлэх ахлах байцаагч, дэслэгч
	С.Тэмүүжин	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн албаны ойн ургамлын ашиглалт хариуцсан мэргэжилтэн

2.

2.Зэрлэг байдлаар ургаж буй ургамлын тархцыг зогсоох, устгах ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулж арга хэмжээний явц, үр дүнг 2024 оны 07 дугаар сарын 21-ний дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн хошууч (Д.Батсүрэн)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ